

ХЯТАДЫН ЦЭРЭГ, БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ БА “БҮС, ЗАМ” САНААЧИЛГЫН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Б.Эрдэнэчимэг

*Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний
хүрээлэн, доктор, дэд профессор*

М.Хонгорзул

*Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний
хүрээлэн, докторант*

Товч агуулга: БНХАУ нь нэг дэх 100 жилийн ойгоор цэцэглэн хөгжсөн нийгмийг бүрэн байгуулах, хоёр дахь 100 жилийн ойгоор баян, хүчирхэг ардчилсан соёл иргэншилтэй, орчин үеийн социалист улсыг байгуулахаар зорьж байна. Энэ нь Хятад үндэстний агуу их сэргэн мандалтад хүрэх мөрөөдөл бөгөөд хэрэгжүүлэх гол стратеги нь “Бүс ба зам” санаачилга болон хүчирхэг зэвсэгт хүчнийг байгуулах явдал юм.

“Бүс ба зам” санаачилгын хүрээнд хэрэгжиж буй томоохон төслүүдийн нэг нь Африк, Европ тивийн улс орнуудыг далай тэнгисээр холбох “Далайн торгоны зам” төсөл юм. Энэхүү төслийн хүрээнд тус улс гадаад далай дахь геостратегийн ач холбогдол бүхий газруудад бүтээн байгуулалт өрнүүлж, дэд бүтцийг хөгжүүлэх замаар “хилийн чанад дахь дэмжлэгийн систем” байгуулан, гадаадад цэргийн ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх олон төрөлт үүрэг зориулалт бүхий ар тал хангалт, дэмжлэгийн “цэг” байгуулахыг эрмэлзэж байна.

Түлхүүр үг: бүс ба зам, далайн торгоны зам, стратегийн тэлэлт, тэнгисийн цэрэг, стратегийн түшиц цэг, дэмжлэгийн систем, цэргийн бааз

Abstract: People’s Republic of China commits to fully establish prosperous society by its first centennial anniversary and to establish rich and powerful socialist nation with democratic civilization by second centennial anniversary. This is China’s dream to rich great renaissance and main strategy is “Belt and Road” initiative and powerful armed forces.

One of the grand projects of “Belt and Road” initiative is “Maritime Silk road” project which commits to connect African and European nations by sea. In relevance to this project, China commits to establish military logistics and support “focal points” to support

its military operations overseas and to establish “overseas support system” by starting constructions and developing infrastructure in territories with geostrategic importance.

Хятадын цэргийн номлолд гарч буй өөрчлөлтүүд

Цэргийн номлол нь дайны зорилго шинж чанар, улс орон болзошгүй дайнд бэлтгэх, дайн хийх арга хэлбэр, цэргийн байгуулалтын талаарх удирдамж юм. БНХАУ-ын цэргийн номлол 1949 оноос хойш хэд хэдэн удаа шинэчлэгджээ.

Мао Зедуны 1930-аад онд боловсруулсан “Ардын дайны (人民战争)” үзэл баримтлал нь БНХАУ-ын цэргийн номлол, стратегийг тодорхойлж ирсэн. **“Ардын дайн”-ы номлол** нь Японы эсрэг дайн, Гоминданы эсрэг байлдааны ажиллагаанд ашиглагдаж, улмаар нэг дайнаас нөгөө дайны хооронд улам бүр боловсронгуй болж ирсэн. Тэрээр “Ардын дайны” цэргийн номлолд **Зүүн хойд чиглэлд АНУ-ыг гол сөргөлдөгчөө** гэж үзэн, зэр зэвсэг, технологийн хувьд давуу дайсны эсрэг байлдааны ажиллагаанд “хүний хүчин зүйл”-ийг чухалчилж үзсэн байдаг.

Харин ХАЧА 1969 оны Зөвлөлт-Хятадын хилийн мөргөлдөөний дараа Зөвлөлтийн эсрэг болзошгүй дайнд эрчимтэй бэлтгэж, хуучны цэргийн номлолыг ашиглах нь гарцаагүй ялагдалд хүргэнэ хэмээн цэргийн номлолоо шинэчилж, 1977 онд **Төв хойд чиглэлд ЗХУ-ын эсрэг “Идэвхтэй хамгаалалт-Дайсныг нутгийн гүнд татан оруулах” номлолыг** хэрэгжүүлсэн.

1980 оны 9 дүгээр сард Хятадын Зэвсэгт Хүчний Жанжин штаб хуралдаж, ЗХУ-ын болзошгүй дайралтын эсрэг хэрхэн хариу цохилт өгөх тухай дахин хэлэлцэж, үр дүнд нь **“Ардын дайн”-ы шинэчилсэн хувилбар болох “Орчин цагийн нөхцөл дэх Ардын дайн” гэсэн шинэ номлолыг** баталсан.¹

1990-1991 оны Персийн булангийн дайны дараа Хятадын цэргийн шинжээчид орчин үеийн байлдааны ажиллагаанд дэвшилтэт технологи чухал болохыг соргоогоор мэдэрч, ирээдүйн дайн шинэ технологийн дайн байна гэж үзсэн учир БНХАУ-ын Цэргийн Төв Зөвлөл 1993 оны 1 дүгээр сард хуралдаж, **Зүүн өмнөд чиглэлд Тайваний эсрэг “Орчин үеийн өндөр технологи бүхий нөхцөлд хязгаарлагдмал дайнд ялалт байгуулах” шинэ цэргийн номлолоо** боловсруулан гаргажээ. Хамгийн чухал нь тус шинэ цэргийн номлолоор ирээдүйд дайн хаана дэгдэж болзошгүй гэдгийг тодорхойлохыг зорьсон. Энэхүү цэргийн номлол нь “Хятад улс хил хязгаарынхаа ойролцоох “зах хүрээ” газар оронд тулгарч болзошгүй хязгаарлагдмал дайн буюу² хил орчмын бүс нутаг эсвэл усан хилийн ойролцоох орон зайд үүсэх зөрчил, мөргөлдөөний тухай юм.

Паул Годвиний тодорхойлсноор, 1993 оны номлолоор цэргийн стратегийн чиглэлд гарсан нэг өөрчлөлт нь ХАЧА эх газрыг хамгаалахад гол ач холбогдол өгдөг байсан бол далай тэнгис дэх газар нутгийн маргаан, ашиг сонирхлыг хамгаалахад


1 M. Taylor Fravel, *Active Defense: China’s Military Strategy since 1949* (Princeton, NJ: Princeton University Press, 2019).

2 Мөн тэнд

анхаарал хандуулах болсон¹.

2004 оны 6 дугаар сард БНХАУ-ын Цэргийн Төв зөвлөлийн өргөтгөсөн хурлаар Зүүн өмнөд чиглэлд Тайвань болон АНУ-ын эсрэг гол анхаарлаа хандуулж, **“Мэдээлэлжсэн нөхцөлд хязгаарлагдмал дайнд ялалт байгуулах” цэргийн номлолыг** баталсан.² Тус номлолын өмнөх цэргийн номлолоос ялгагдах гол онцлог нь “өндөр технологи” гэдэг үгийг “мэдээлэлжсэн” гэсэн үгээр сольж, дэвшилтэт технологид суурилсан дайны гол шинж нь мэдээлэлжих явдал тул Зэвсэгт хүчний анхаарлыг энэ чиглэлд хандуулахыг зорьсон. Мэдээлэлжих гэдэг нь нэгдсэн ажиллагаа явуулахад Зэвсэгт хүчний төрлийн цэргүүд хоорондын мэдээллийн урсгалын уялдаа холбоог хангах тухай юм. Өөрөөр хэлбэл, мэдээлэлжсэн дайн гэдэг нь электрон-соронзон болон газар, ус, агаар, сансар, кибер орон зайд Зэвсэгт хүчин төрлийн цэргүүдийн нэгдсэн байлдааны ажиллагаа явуулахад мэдээлэл олж авах, дамжуулах, боловсруулах, ашиглах үйл явцтай холбоотой юм.³

1 дүгээр зураг. Аюулын зэрэглэлийн 4 тойрог.



Эх сурвалж: Rand 2018

2014 оны номлолоор Хятадын Зэвсэгт хүчин удирдлага, хяналт, холбоо, компьютер, тагнуул, тандалт, туршуул (C4ISR)-ын технологид хөрөнгө оруулалт хийж, энэ чиглэлд чадавхийг сайжруулахад анхаарал хандуулахыг чухалчлан Зүүн өмнөд болон далай тэнгисийн чиглэлд Тайвань, АНУ-ын эсрэг **“Мэдээлэлжсэн хязгаарлагдмал дайнд ялалт байгуулах” номлолыг** хэрэгжүүлсэн. “Мэдээлэлжсэн

1 Paul H.B. Godwin, “Change and Continuity in Chinese Military Doctrine, 1949–1999”, in Chinese Warfighting: The PLA Experience since 1949, ed. Mark A. Ryan, David M. Finkelstein, and Michael A. McDevitt (Armonk, NY: M. E. Sharpe, 2003).
 2 M. Taylor Fravel, Active Defense: China’s Military Strategy since 1949 (Princeton, NJ: Princeton University Press, 2019).
 3 Larry M. Wortzel, “The Chinese People’s Liberation Army And Information Warfare” <https://publications.armywarcollege.edu/pubs/2263.pdf>

дайн” болоод “мэдээллийн дайн” гэсэн хоёр ойлголт нь ялгаатай бөгөөд мэдээллийн дайн нь мэдээлэлжсэн дайны зөвхөн нэг хэсэг гэж үздэг.

1990-ээд оноос хойш цэргийн номлолд гарсан өөрчлөлтийг дүгнэж хэлвэл, ирээдүйн дайны шинж чанар нь технологижсон, мэдээлэлжсэн нөхцөлд хязгаарлагдмал орон зайд буюу хил дагуух зах хүрээ бүс нутагт богино хугацаанд “түргэн” бөгөөд “ширүүн” дайн өрнөх магадлалтай тул шинэ технологи, инновацийг дэмжих, мэдээллийн ажиллагааны чадавхийг сайжруулах төрлийн цэргүүдийн нэгдсэн ажиллагааг сайжруулах, дайны бус цэргийн ажиллагааг дэмжихэд батлан хамгаалах бодлого, цэргийн стратегийг чиглүүлж байна.

ХАЧА-ийн цэргийн шинэчлэл

Сүүлийн жилүүдэд Хятадын ардын чөлөөлөх арми (ХАЧА) нь шинжлэх ухаан, техник, технологийн дэвшлийн дагуу цэргийн шинэчлэлт хийж байгаа бөгөөд 2020 он гэхэд энэхүү шинэчлэлийн эхний үе шат бүрэн дууссан байна.

Үүнтэй холбогдон Хятадын батлан хамгаалах төсөв, зардал тогтмол өсч буй нь сүүлийн үед хийгдээд буй ХАЧА-ийн бүтцийн болон зэвсэглэл, техникийн шинэчлэл, байнгын сургалт бэлтгэлтэй салшгүй холбоотой юм.

ХАЧА цэргийн шинэчлэлийн хүрээнд орчин үеийн зэвсэг, техникээр хангагдаж буй хэдий ч бодит байлдааны ажиллагааны туршлага дутагдалтай байдал нь томоохон сул тал болж байна. ХАЧА 1979 онд Вьетнамтай хийсэн дайнаас хойш сүүлийн 40 гаруй жил томоохонд тооцогдох дайн тулаанд оролцоогүй нь АНУ зэрэг орнуудтай харьцуулахад орчин үеийн байлдааны туршлага дулимаг гэж тооцогдож буй. Мөн түүнчлэн Тайваньтай тулгарсан тохиолдолд газар-усны байлдааны чадавх, туршлагын асуудал хөндөгдөнө. ХАЧА-ийн газар-усны байлдааны туршлагын тухайд зарим нэг жижиг тулааныг эс тооцвол 1955 онд Гоминьдантай хийсэн байлдаанаас хойш мөн л далай тэнгист томоохон тулаанд оролцоогүй гэж хэлэхэд хилсдэхгүй.

ХАЧА Адений булан дахь далайн дээрэмтэй тэмцэх ажиллагаа, энхийг сахиулах ажиллагаа, хямралыг намжаах болон аврах ажиллагаа зэрэг олон улсын хүмүүнлэгийн болон цэргийн ажиллагаанд идэвхтэй оролцож буй хэдий ч бодит байлдааны туршлагыг орлохгүй гэдэг нь ойлгомжтой. Тиймээс сүүлийн жилүүдэд ХАЧА байлдааны цагийн байдалд ойртуулсан нөхцөлд эрчимжсэн сургалт, дадлага явуулж, бие бүрэлдэхүүнээ чадавхжуулахад онцгой анхаарч байна. БНХАУ Өмнөд болон Зүүн Хятадын тэнгист АНУ-тай зөрчил, мөргөлдөөнд татагдан орсон тохиолдолд “дарийн утаа үнэрлээгүй цэрэг” бүрэн ялалт авчирна гэж төсөөлөхөд бэрх юм.

Нөгөө талаас нь харвал ХАЧА уламжлалт дайны тухай ойлголтоос хэдэн нүүдлийн цаадахыг харж, сэтгэж ирээдүйн дайнд бэлтгэж буй. Хятад улс ирээдүйн дайнд хиймэл оюун ухаан, технологийн дэвшлийг ашиглан илүү “мэдээлэлжсэн” цэрэг “ухаалагжсан” зэвсэг, техниктэйгээр оролцохоор эрмэлзэж байна. Цэргийн шинэчлэлийн хүрээнд Зэвсэгт хүчинд төрөл бүрийн робот технологи, ухаалаг зэвсэг,

техникийг нэмж, улмаар 2030 он гэхэд “6G” технологийг зэвсэглэлд нэвтрүүлвэл дайснаасаа хэд дахин илүү “мэдээлэлжсэн”, илүү “ухаалаг” зэвсэгтэйгээр давуу байдлыг эзэмших боломжтой болно гэж үзэж байна. Гэвч технологийн хувьд давуу байдал эзэмшлээ гэхэд бие бүрэлдэхүүнийг хурдацтай өөрчлөгдөж буй технологийн шинэчлэлээс хоцролгүй сургаж бэлтгэх асуудал чухлаар тавигдаж байна. Өөрөөр хэлбэл, технологийн үсрэнгүй хөгжлийг дагаад богино хугацаанд дасан зохицох, технологийн өндөр чадвартай бие бүрэлдэхүүнтэй байхыг шаардаж буй. Энэ тухайд ХАЧА тусгай үүргийн цэргийн төрлийг нэмэгдүүлж чиглэл, чиглэлээр мэргэшсэн багуудыг бэлтгэж байна. ХАЧА-ийн нүсэр бүтцээс улбаалсан шат дараалсан хүнд суртал зэрэг асуудал нь зэвсэг, техникийн хөгжилтэй зэрэгцэн цаг тутам өөрчлөгдөж буй байлдааны шинэ орчин нөхцөлд бие бүрэлдэхүүнийг богино хугацаанд чадавхжуулж, бэлэн байдлыг хангахад хүндрэл учруулж байна. Тиймээс ч ХАЧА-д хийж буй шинэчлэлийн хүрээнд цэргийн байгуулалтын шинэчлэл явагдсан бөгөөд үр дүнг нь нарийн тодорхойлоход арай эртдэх бизээ.

ХАЧА-ийн цэргийн шинэчлэлийн ажлууд, цэргийн сургалт бэлтгэл, ай болон төрлийн цэргүүдийн бие бүрэлдэхүүн болоод зэвсэг техникийн цэргийн бүсүүд дэх хуваарилалт, зохион байгуулалтыг ажиглахад Ази, Номхон далайд, тэр дундаа Зүүн болон Өмнөд Хятадын тэнгис дэх болзошгүй зөрчил мөргөлдөөнд бэлтгэж, байлдааны бэлэн байдлаа хангаж байна гэж үзэж болох талтай.

Харин далай тэнгист зэвсэгт тэмцэлд бэлдэхэд тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлуудын нэг нь ХАЧА-д Хуурай замын цэрэг давамгайлсан байдал буюу түүхэн гүйцэтгэсэн үүрэг, уламжлалаараа цэргийн удирдлагын ширээнээс байлдааны талбар хүртэлх бүхий л хүрээнд Хуурай замын цэрэг голлох үүрэгтэй байдаг явдал юм. Тиймээс цэргийн шинэчлэлийн хүрээнд ХАЧА-д Тэнгисийн цэрэг, Агаарын цэрэг, Пуужинт цэргийн байр суурийг дээшлүүлж, ай цэргүүдийн тэнцвэрийг хадгалах замаар төрлийн цэргүүдийн хамтран нэгдсэн байлдааны ажиллагаа явуулах чадавхийг сайжруулах нөхцөл бүрдүүлэхийг зорьж байна. Тухайлбал, цэргийн таван бүсийн хоёрынх нь захирагчаар Агаарын болон Тэнгисийн цэргээс томилж, байлдааны ажиллагааны командлалын шатлалаас төрлийн цэргүүдийн дарга нарыг хасч, оронд нь цэргийн таван бүсийн удирдлагуудад өөрийн цэргийн тойрог дахь цөмийн пуужингийн цэргээс бусад цэргийн хүчнийг удирдан чиглүүлэх эрх олгосон явдал юм.

Төрлийн цэргүүдийн хамтарсан ажиллагааны уялдаа холбоог сайжруулахын тулд “Стратегийн дэмжлэг үзүүлэх цэрэг”, “Ар тал хангалт, дэмжлэгийн нэгдсэн цэрэг” байгуулахын сацуу төрлийн цэргүүдийн нэгдсэн ажиллагааны сургалтын стандартыг боловсруулах, хамтарсан сургууль, дадлагын үр дүнг ахиулахын тулд ЦТЗ-ийн харьяа “Сургалт хариуцсан газар”-ыг шинээр байгуулсан зэрэг нь төрлийн цэргүүдийн байлдааны нэгдсэн ажиллагаа явуулах чадавхийг сайжруулахад нилээдгүй ач холбогдол өгч буйн илрэл юм.

БНХАУ хүчирхэг цэрэг армитай болж буйн хамтаар бүс нутагтаа төдийгүй олон улсын тавцанд нөлөө бүхий их гүрэн болохоор эрмэлзэж байна. “Бүс, зам” санаачилгыг хэрэгжүүлж эхэлснээс хойш “Далайн торгоны зам” дагуу цэргийн

зориулалттай “стратегийн цэг”-үүд байгуулж, гадаад дахь цэргийн оролцоогоо нэмэгдүүлэх алхамууд хэрэгжүүлж байна.

Далайн торгоны зам дагуух хилийн чанад дахь цэрэг, стратегийн тэлэлт

Ази, Африк, Европ тивийн улс орнуудыг далай тэнгисээр холбох “Далайн торгоны зам” төсөл хэрэгжиж эхэлснээр усан замын аюулгүй байдлыг хангах Тэнгисийн цэргийн үүрэг нэмэгдэж байна. БНХАУ “Бүс, зам”-ын хүрээнд геостратегийн ач холбогдол бүхий суваг, хоолой зэрэг газрууд, тэдгээрийн ойролцоох боомтуудад бүтээн байгуулалт өрнүүлэн, дэд бүтцийг хөгжүүлж, улмаар хилийн чанадад Хятадын урт хугацаагаар түрээсэлж буй боомтуудыг ашиглан тэнгисийн цэрэгт дэмжлэг үзүүлэх “стратегийн түшиц цэг” буюу тэнгисийн цэргийн түлш шатахуун зэрэг ар тал хангалтын асуудлыг шийдээд зогсохгүй хөлөг онгоцны засвар үйлчилгээ, тагнуулын мэдээлэл цуглуулах гээд олон төрөлт үүрэг зориулалт бүхий “дэмжлэгийн цэг” байгуулан, боомтод суурилсан тэдгээр сүлжээг бүхэлд нь “Хилийн чанад дахь дэмжлэгийн систем” гэж нэрлэн харилцан уялдаа холбоог ханган ажиллахыг зорьж буй ажээ.

Тиймээс сүүлийн жилүүдэд Хятадын төрийн өмчит болон төрийн хувь эзэмшдэг компаниуд Ази, Африк, Ойрхи Дорнод, Европт стратегийн чухал ач холбогдол бүхий далай, тэнгисийн боомтуудыг урт хугацаагаар түрээслэн боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд идэвхийлэн оролцож эхэлжээ. Тухайлбал, Чайна Мерчант Порт компани Шри-Ланкийн Коломбо, Хамбантотагийн боомтууд, Улаан тэнгисийн орц, гарц дээрх Жибутигийн боомтууд, Нигерийн Лагостине зэргийг оролцуулаад “Бүс, зам”-ын дагуу дэлхийн 19 оронд 49 боомт эзэмшиж, 2 тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн бол КОСКО Шиппинг групп Абу Дабигийн боомт, Бельгийн Антверп, Зибружегийн боомтууд, Нидерландын Роттердамын боомт, Испанийн Валенсиагийн боомт зэргийг оролцуулаад “Бүс, зам”-ын дагуух 11 боомт, нийт 20 боомтод хөрөнгө оруулалт хийжээ.¹

Шанхай-Хонгконг Групп Израйлийн Хайфагийн шинэ боомтын терминалыг 2021 оноос эхэлж, 25 жил ажиллуулах эрхийг 2015 онд тендерт ялж авав.² Ойрх Дорнод дахь Америкийн холбоотон Израйлийн Хайфа боомтыг 2021 оноос Хятадын төрийн өмчит компани түрээслэх болсон нь Америкийг багагүй тэвдүүлж байна. Тэрээр Америкийн тэнгисийн цэргийн 6 дугаар флот буудалладаг Израйлийн Тэнгисийн цэргийн баазын ойролцоох уг боомтыг түрээслэх болсныг Америкийн Тэнгисийн цэргийн талаар тагнуулын мэдээлэл цуглуулах, Израйлийн дэвшилтэт технологийн нууцыг тандах зорилготой байж болзошгүй гэж хардаж байна.³ Мөн

1 以港口为战略支点书写21世纪海上丝绸之路建设新篇章
https://www.sohu.com/a/242651424_784079


2 мөн тэнд

3 “Pentagon repeats warning to Israel on Chinese port deal” <https://www.al-monitor.com/pulse/originals/2019/08/pentagon-repeat-warning-israel-china-port-deal.html#ixzz6Q8xJBuO2>

түүнчлэн Чиндао Порт групп Мэерск групптэй хамтран Италийн Вадо Лигур боомт, Ризао Порт Групп 2016 оноос Пакистаны Касим боомт, 2018 онд Хятадын Геологийн Инженерийн Групп болон Хятадын Шинэ Эрин Холдингтой хамтран Гвинейн Конакри боомтод тус тус хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийж, удирдан ажилуулж байна.¹

БНХАУ-ын цэргийн гадаад ажиллагаанд Тэнгисийн цэрэг голлох жин нөлөөтэй оролцож буй бөгөөд *ХАЧА-ийн Тэнгисийн цэрэг усан замын аюулгүй байдал хангах болон хилийн чанад дахь улсынхаа ашиг сонирхлыг хамгаалах* гэсэн хоёр үндсэн үүрэгтэй ажиллаж байна.

2 дугаар зураг. Тэнгисийн цэргийн усан замын хамгаалалтын маршрут.



Эх сурвалж: US Naval intelligence

2019 оны “Шинэ эринд баримтлах Хятадын батлан хамгаалах бодлого” Цагаан номонд Зэвсэгт хүчний үндсэн үүргийн нэг нь “Хилийн чанад дахь Хятадын иргэд, байгууллага, нэгжийн аюулгүй байдал, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг үр дүнтэй хамгаалах” гээд “ХАЧА олон улсын аюулгүй байдал, цэргийн хамтын ажиллагааг дэмжиж, хилийн чанад дахь ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай механизмыг боловсронгуй болгохыг дэмжиж буй”-г тусгасан.² Мөн тус цагаан номонд “Хилийн чанад дахь цэргийн ажиллагаа, ажиллагааны дэмжлэгийг сайжруулахад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд ХАЧА гадаад далай дахь цэргийн хүчин, ар тал, дэмжлэгийн байгууламжууд байгуулж буй”³ талаар онцолсон.

ХАЧА усан замын аюулгүй байдлыг хамгаалах Тэнгисийн цэргийн үүргийг дэмжих хүрээнд “Далайн торгоны зам” дагуу боомтуудад “стратегийн түшиц

1 以港口为战略支点书写21世纪海上丝绸之路建设新篇章

https://www.sohu.com/a/242651424_784079

2 新时代的中国国防。白皮书 http://www.mod.gov.cn/regulatory/2019-07/24/content_4846424.htm

3 Мөн тэнд

цэгүүд” (strategic strong points)-ийг байгуулахыг зорьж байгаа ажээ. Гадаадын улс орнууд дахь стратегийн түшиц цэгүүд Хятадын цэргийн хилийн чанадад ажиллагаа явуулах хүчин чадавхийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. 2017 онд Жибутид байгуулагдсан цэргийн бааз нь ХАЧА-ийн хилийн чанад дахь анхны “стратегийн түшиц цэг” гэж нэрлэгдэж буй.¹ Стратегийн түшиц цэгүүд (*dian*, 点 points) байгуулж, ар тал хангалт, дэмжлэгийн асуудлыг шийдвэрлэснээр тэнгисийн цэргийн Хятадын эх газраас алслагдмал зайд ажиллагаа явуулах хүчин чадавх нэмэгдэх юм.² ХАЧА хилийн чанад дахь урт хугацаагаар түрээсэлж буй боомтууд дээр байгуулсан Тэнгисийн цэрэгт дэмжлэг үзүүлэх “стратегийн түшиц цэг” -үүдийн уялдаа холбоог ханган, гинжин хэлхээ бүхий “Хилийн чанад дахь дэмжлэгийн систем” (overseas support system) байгуулахыг зорьж байна.³

2 дугаар зураг. Түлш шатахуун цэнэглэдэг боомтууд.



Эх сурвалж: Stratfor 2015


“Хилийн чанад дахь дэмжлэгийн систем” гэдэг нь хөлөг онгоцны түлш шатахуун зэрэг ар талын хангалтын асуудлыг шийдвэрлээд зогсохгүй тэнгисийн цэргийн үйл ажиллагааг дэмжих иж бүрэн зориулалт бүхий харилцан уялдаа холбоотой ажиллах “Далайн торгоны зам”-ын боомтууд даган байрласан “стратегийн түшиц цэг”-үүд гэж ойлгож болно.

1 刘琳: “一带一路”沿线战略支点与军事外交建设 <http://m.dunjiaodu.com/waijiao/1562.html>

2 Connor Kennedy “strategic strong points and Chinese naval strategy” <https://jamestown.org/program/strategic-strong-points-and-chinese-naval-strategy/>

3 Мөн тэнд

3 дугаар зураг. Түшиц цэг байгуулах зураглал.



Эх сурвалж: Jamestown

2016 оны Тэнгисийн хүчний стратегийн форумд Дайланий Тэнгисийн цэргийн академийн судлаач багш “Далайн торгоны зам дагуу стратегийн түшиц цэгүүд” байгуулах “Түшиц газар, эргийн шугам, фронтын стратеги”-ийг тайлбарласан. Хятадын цэргийн судлаачдын зүгээс хилийн чанадад цэргийн бааз байгуулахыг дэмжиж, стратегийн түшиц цэгүүд байгуулах ажлыг бодитоор төлөвлөн ажил хэрэг болгохоос гадна эргийн шугамууд хоорондоо давхардахгүй байх мөн стратегийн хувьд хамгийн чухал газруудад түшиц цэгүүдийг нэн түрүүнд байгуулах нь зүйтэй гэсэн санал дэвшүүлж буй ажээ.¹ Нөгөөтээгүүр, Хятадын цэрэг, стратегийн тэлэлтийг гадаадын улс орнууд эмзэглэнгүй хүлээж авах вий гэж “стратегийн түшиц цэг”-үүдийн хоорондын холбоос болоод “стратегийн түшиц цэг” фронт” хоорондын хамаарлыг тайлбарлах асуудал дээр Хятадын судлаачдын зүгээс тун болгоомжлонгуй хандаж байна.²

Учир нь Энэтхэг улсын хувьд Номхон далай, Энэтхэгийн далай дахь Хятадын тэнгисийн цэргийн тэлэлтийг “Сувдан хэлхээ” (Strings of pearls) геополитик буюу Хятадын худалдаа, цэргийн байгууламж, баазуудаар Номхон далайд АНУ болон түүний холбоотнууд, Энэтхэгийн далайд Энэтхэгийг тойруулан хашаалж, цэрэг стратегийн давуу байдлыг бий болгож байна гэж үзэх болсон.³

1 Connor Kennedy “strategic strong points and Chinese naval strategy” <https://jamestown.org/program/strategic-strong-points-and-chinese-naval-strategy/>

2 Мөн тэнд


3 Maninder Dabas, “Here is All You Should Know About ‘String of Pearls,’ China’s Strategy to Encircle India,” India Times, June 23, 2017, <https://www.indiatimes.com/news/india/here-is-all-you-should-know-about-string-of-pearls-china-s-policy-to-encircle-india-324315.html>

4 дүгээр зураг. “Сувдан хэлхээ” (Strings of pearls).



Эх сурвалж: Indiatimes

5 дугаар зураг. “Сувдан хэлхээ” (Strings of pearls).



Эх сурвалж: Indiatimes

Индия таймс цахим хуудсанд мэдээлснээр “Энэтхэг улс хэдийнээ Хятадад “хашигдаад” буй бөгөөд Пакистаны хөрсөн дээр Хятадын цэргийн бааз байгуулагдвал “Сувдан хэлхээ”-ний сүүлийн сувд хэлхэгдэж, БНХАУ стратегийн зорилгодоо хүрэх болно”¹ гэжээ.

Хилийн чанадад ХАЧА-ийн Тэнгисийн цэргийн бааз байгуулах тухайд

Хятадын Тэнгисийн цэргийн стратегид тэргүүлэх ач холбогдол бүхий газруудад Энэтхэг, Номхон далай орж буй бөгөөд ХАЧА-ийн хилийн чанад дахь дараагийн “стратегийн түшиц цэг”-үүд Жибутигээс гадна Шри-Ланкийн Хамбантота болон Пакистаны Гвадар боомтын ойролцоо байгуулагдаж магадгүй гэж судлаачид таамаглаж буй.²

6 дугаар зураг. Энэтхэг-Номхон далай дахь Хятадын хөрөнгө оруулалттай боомтууд.



Эх сурвалж: Center for Advanced Defense Studies

1 Мөн тэнд

2 “All that Xi wants: China attempts to ace bases overseas” https://www.brookings.edu/wp-content/uploads/2019/09/FP_20190930_china_basing_karlin_dreyfuss.pdf

2013 оноос хойш Өмнөд Хятадын тэнгис, Энэтхэгийн далайд
Хятадын эзэмшиж буй боомтууд

Он	Бүс нутаг	Улс	Боомт	Түрээслүүлсэн хугацаа
2015	Энэтхэгийн далай	Пакистан	Гвадар	40
2015	Энэтхэгийн далай	Мьянмар	Кяукпю	50
2015	Өмнөд Хятадын тэнгис	Малайз	Куантан	60
2016	Энэтхэгийн далай	Жибути	Обок	10
2016	Өмнөд Хятадын тэнгис	Малайз	Мелака гарц	99
2017	Энэтхэгийн далай	Шри Ланк	Хамбантота	99
2017	Өмнөд Хятадын тэнгис	Бруней	Муара	60
2017	Энэтхэгийн далай	Малдив	Фэйдхо Финолху	50

Эх сурвалж: Стокольмын Олон улсын Энх тайвны судалгааны хүрээлэн, 2019.

Шри Ланк улс “Бүс, зам” санаачилгын хүрээнд БНХАУ-аас 1 тэрбум гаруй доллар зээлж, Хамбантота боомтыг бариулсан боловч зээлээ эргэн төлөх боломжгүйн улмаас тус боомтыг 99 жилийн хугацаатай түрээслүүлэхээр болсон.¹ Шри Ланкийн Засгийн газар болон Коломбо дахь Хятадын Элчин сайдын яамнаас боомтыг цэргийн зориулалтаар ашиглахгүй гэдгээ мэдэгдсэн хэдий ч Хятадын хилийн чанадад түрээсэлж буй боомтууд дундаас хамгийн урт хугацаанд түрээсэлж буй боомт гэдгээрээ цэргийн зориулалтаар ашиглах магадлалтай байгаа юм.

Пакистаны Гвадар боомтыг 2015 оноос Хятадын төрийн өмчит компани 40 жилийн хугацаагаар түрээсэлж байгаа бөгөөд боомтын дэд бүтцийн ажил дууссанаар Малаккын хоолойгоор дамждаг далайн тээврийн замыг хэд дахин богиносгосон Хятадыг Энэтхэгийн далайтай холбох дөт гарц нээгдэх юм. Хятадын Ерөнхий сайд Ли Кэцян 2013 онд Пакистанд айлчлах үеэрээ анх Хятад–Пакистаны эдийн засгийн коридор байгуулах санал дэвшүүлсэн ба “Бүс, зам” санаачилгын хүрээнд Хятад–Пакистаны эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтад 62 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэх ажээ.² “Глобал таймс” цахим хуудаснаа мэдээлснээр Пакистан улс 2018 онд Хятадын “Сансрын клуб” буюу хиймэл дагуулын системд нэгдсэн ба БНХАУ-ыг “төмөр ах” гэж авгайлан ойр дотно, түншийн харилцааг хөгжүүлж байгаа ажээ.³

1 Game of loans: How China bought Hambantota <https://www.csis.org/analysis/game-loans-how-china-bought-hambantota>

2 “China-Pakistan: A journey of friendship (1950-2020)” <https://www.globaltimes.cn/content/1189007.shtml>

3 Мөн тэнд

2021 онд Хятад-Пакистаны дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой тохиож, хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа ирэх жилүүдэд өргөжих төлөвтэй байна. Гвадарт Хятадын цэргийн бааз байгуулах нь олон улсад “Бүс, зам” санаачилгын нэр хүнд, өнгө төрхөд сөргөөр нөлөөлнө гэж Хятадын зүгээс тооцоолж байгаа тул өөр газар байгуулж магадгүй гэсэн таамаглал бий. “Вашингтон таймс” цахим хуудаснаа Ираны хил, Оманы булангийн ойролцоо Пакистаны Живанид Хятадын тэнгисийн цэргийн бааз, агаарын цэргийн байгууламж байгуулагдана гэж мэдээлэв.¹ Мөн тэнд мэдээлснээр ХАЧА-ийн болон Пакистаны цэргийн төлөөлөгчид Живанид уулзалт хийж, БНХАУ-ын зүгээс Пакистаны талд тэнгисийн цэргийн бааз барих зориулалтаар ойр орчмын иргэдийг нүүлгэн шилжүүлэх мөн ХАЧА-ийн байлдааны нисэх онгоцыг хүлээж авахад бэлтгэж нисэх зурвас, онгоцны буудлыг шинэчилж, засварлах хүсэлт тавьжээ.² БНХАУ-ын “Глобал таймс” мэдээний цахим хуудаснаа хилийн чанад дахь Хятадын хоёр дахь цэргийн бааз баригдах гэж буй гэсэн шуугианы талаар хариулт өгч, “АНУ нь Энэтхэг рүү чиглэсэн стратеги хэрэгжүүлж, Хятад, Пакистаны эгдүүцлийг төрүүлвэл хариу болгож, БНХАУ, Пакистан хоёр улс цэргийн хамтын ажиллагаагаа өргөжүүлж болох юм” гэж мэдэгдэв.³

БНХАУ-ын Фуданий их сургуулийн Өмнөд Ази судлалын төвийн профессор Лин Минван “Бээжин, Исламабадын хамтарсан тэнгисийн цэргийн бааз, агаарын цэргийн байгууламжийг Пакистанд байгуулах боломж, чадавх байгаа хэдий ч одоогоор бааз байгуулах хэрэгцээ шаардлага алга”⁴ гэж “Глобал таймс”-д мэдээлжээ. “Хэрвээ АНУ холбоотнуудын хамтаар “Энэтхэг-Номхон далайн стратеги”-аа

7 дугаар зураг. Живанигийн боомт



1 “China building military base in Pakistan” <https://www.washingtontimes.com/news/2018/jan/3/china-plans-pakistan-military-base-at-jiwani/>

2 “China building military base in Pakistan” <https://www.washingtontimes.com/news/2018/jan/3/china-plans-pakistan-military-base-at-jiwani/>

3 “Trump tweet draws China, Pakistan closer” <https://www.globaltimes.cn/content/1083361.shtml>

4 Мөн тэнд

хэрэгжүүлэх гэж мэрийх аваас Хятад улс далайн замын аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөгөө Пакистаны хамтаар хэрэгжүүлэх нь дамжиггүй” хэмээсэн нь Америк, Энэтхэгтэй дотносвол Хятад Пакистанд цэргийн бааз байгуулах төлөвлөгөөгөө хэрэгжүүлнэ гэсэн байр суурийг илтгэж байна. Живани нь Гвадар боомтоос 60 орчим километрийн зайд оршдог ч Гвадарыг бодвол Оманы булан дагуу Хормузын хоолой, Ираны Чабахар боомттой ойр стратегийн чухал байршил бүхий боомт юм.

Хэдийгээр Хятадын зүгээс одоогоор Пакистанд цэргийн бааз байгуулахгүй гэж мэдэгдэж байгаа ч дараах хоёр нөхцөл байдлын улмаас цэргийн бааз байгуулах хэрэгцээ шаардлага үүсч болзошгүй гэж үзэж байна.

Нэгдүгээрт, террорист бүлэглэл, хэт даврагчдаас хилийн чанад дахь Хятадын иргэд, өмч хөрөнгийг хамгаалах хэрэгцээ шаардлагын улмаас Балучистан мужийн Живанид цэргийн бааз байгуулах нөхцөл үүсч магадгүй юм.

2013 оны “Зэвсэгт хүчний олон талт хэрэглээ”, 2019 оны “Шинэ эринд баримтлах Хятадын батлан хамгаалах бодлого” Батлан хамгаалахын цагаан номд ХАЧА-ийн нэг үндсэн үүрэг нь “Хилийн чанад дахь хятадын иргэд, байгууллага, нэгжийн аюулгүй байдал, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг үр дүнтэй хамгаалах¹ гэж заасан. 2018 оны 11 дүгээр сард Пакистаны боомт хот Карачи дахь Хятадын консулын газарт Балучийн Чөлөөлөх Армийн (БЧА) зэвсэгт этгээдүүд халдаж, 7 хүний амь үрэгдсэн.² Балучийн салан тусгаарлагчид Хятадын нөлөөг эсэргүүцэж, энэхүү халдлагыг үйлдсэн гэж мэдэгдсэн ба Хятадын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хүрээнд тус бүс нутагт олноор суурьших болсон хятад ажилчдыг “бай”-гаа болгох болсон. 2017 онд Хятад улсын иргэн болох эхнэр, нөхөр хоёрыг барьцаалж хороосон явдлыг Исламын улс бүлэглэл үйлдсэнээ мэдэгдсэн³ бол 2018 оны 8 дугаар сард Иран, Пакистаны хилийн ойролцоох Пакистаны өмнөд нутагт Хятад уурхайн ажилчдыг тээвэрлэж явсан автобус руу амиа золиослогч тэсрэх бөмбөгтэй халдсан үйлдлийг БЧА үйлдсэн гэж зарлав.⁴ 2019 онд Гвадарын 5 одтой зочид буудалд зэвсэгт этгээдүүд гал нээж, БЧА-ийн дайчид Хятадын хөрөнгө оруулагчид руу халдсан болохоо мэдэгджээ.⁵ БЧА-иас гадна өөр нэг зэвсэгт бүлэглэл сүүлийн жилүүдэд хүчээ авсан нь Балучистаны Чөлөөлөх фронт (БЧФ) юм. БЧФ 2020 оны 1 дүгээр сараас 3 дугаар сарын хооронд буюу 3 сарын дотор 26 халдлага үйлдсэн болохоо мэдээлэв.⁶ БЧА, БЧФ хоёр хүчээ нэгтгэн халдлага үйлдэх болсон

1 新时代的中国国防。白皮书http://www.mod.gov.cn/regulatory/2019-07/24/content_4846424.htm

2 “Terror attack on Chinese consulate in Karachi foiled 3-terrorists killed”, November 23, 2018, <https://www.dawn.com/news/1447192/terror-attack-on-chinese-consulate-in-karachi-foiled-3-terrorists-killed>

3 “Abducted Chinese nationals killed claims, IS” June 09, 2017, <https://www.dawn.com/news/1338454/abducted-chinese-nationals-killed-claims-is>

4 “Three Chinese among 6 injured in suicide blast in Pakistan's southwest Balochistan” http://www.xinhuanet.com/english/2018-08/11/c_137383802.htm

5 “Pakistan: Gunmen target luxury hotel in China-funded port city” <https://www.dw.com/en/pakistan-gunmen-target-luxury-hotel-in-china-funded-port-city/a-48701401>

6 “In 3 months, BLF freedom fighters carried 26 attacks on Pakistani forces at Balochistan” <https://www.newsintervention.com/in-3-months-blf-freedom-fighters-carried-26-attacks-on-pakistani-forces-at-balochistan/>

тул Пакистаны арми хариу арга хэмжээ авахад нэлээдгүй бэрхшээлтэй тулгарч байгаа ажээ.¹ Энэ тохиолдолд БНХАУ-ын зүгээс Пакистан дахь хятад иргэд, өмч хөрөнгө, ашиг сонирхлоо хамгаалах үүднээс цэргийн оролцоогоо нэмэгдүүлж болзошгүй гэж үзэж байна.

Хоёрдугаарт, Энэтхэг-Хятадын харилцаа хүйтэрч буй энэ үед Хятад Энэтхэгийн эсрэг хэрэгжүүлэх стратегийн хүрээнд Пакистанд цэргийн оролцоогоо цаашид нэмэгдүүлэхэд хүрч болзошгүй гэж таамаглаж байна. 2020 онд Гималайн нурууны орчмын Галван хөндийд Энэтхэг-Хятадын хил дээр хоёр орны цэргүүдийн хооронд зөрчилдөөн үүсч, 20 цэрэг амь үрэгдэж, хэдэн арван цэрэг шархадсан ба Хятадын талаас албан ёсоор хохирлын тоогоо зарлаагүй болно.² Хятад, Энэтхэгийн хоорондох Ладахын бүс нутагт энэ оны 5 дугаар сараас хойш хэд хэдэн удаа зөрчил үүссэн ч 6 дугаар сарын 5-нд хоёр тал хурцадмал байдлыг намжаахыг тохиролцоод байсан юм. Энэтхэг улсад Хятадын бараа бүтээгдэхүүнд хориг тавьж, Хятадын далбаа болон Ши Жиньпин даргын зургийг шатааж, дэвсэлж Энэтхэгийн иргэд дургүйцлээ илэрхийлж байна.³ Хэрвээ Энэтхэг, Хятадын харилцаа энэ маягаар цаашид хурцадвал Хятад улс Энэтхэгийн хил дээр мөн Пакистанд цэргийн оролцоогоо нэмэгдүүлэх, магадгүй цэргийн бааз барих тал дээр шийдвэртэй алхам хийж болзошгүй юм. Гэвч дээр дурдсанчлан АНУ нь Энэтхэгтэй нийлж, Хятадын эсрэг стратегия эрчимжүүлсэн тохиолдолд Хятад Пакистанд цэргийн бааз барих шалтаг болох нь гарцаагүй бөгөөд үүнийгээ ч хэдийнээ мэдэгдсэн билээ.

Нөгөөтгээгүүр Пакистан, Шри Ланкийн боомтуудад Хятадын тэнгисийн цэргийн бааз байгуулж, хэдэн их наядаар тоологдох “Бүс, зам” төслийг олон улсад Хятадын цэрэг, стратегийн тэлэлт хийж байна гэсэн таамаглалаас зайлсхийж, олны хараа, шүүмжлэлд өртөхгүйгээр шийдвэрлэх өөр нэг гарц хувилбар нь урт хугацаагаар түрээсэлж буй боомтуудыг худалдааны болон цэргийн хосолсон зориулалтаар ашиглах гэсэн нэг хувилбар яригдаж байна. Олон улсын хүмүүнлэгийн тусламж, далайн дээрэмтэй тэмцэх ажиллагаа, аврах ажиллагаа зэрэг сайн үйлсийн хүрээнд ХАЧА-ийн тэнгисийн цэргийн байлдааны хөлөг онгоц “Далайн торгоны зам” дагуух боомтуудыг цэргийн зориулалтаар ашиглах нь олон улсын анхаарлыг татахгүй, бас боомт эзэмшигч улсын зүгээс татгалзах шалтгаангүй илүү оновчтой хувилбар байж болох талтай. Олон улсын шинжээчдийн ажиглаж буйгаар ХАЧА-ийн далайн дээрэмтэй тэмцэх үүрэг гүйцэтгэж буй байлдааны хөлөг онгоцууд Өмнөд Ази, Ойрх Дорнод, Африк дахь Хятадын хөрөнгө оруулалттай буюу Хятадын түрээсэлдэг боомтууд дээр буудалладаг ажээ.⁴

“Хятад улс хилийн чанад дахь аюулгүй байдлын аянд” нэртэй АНУ-ын Ранд

-
- 1 “Amid a Pandemic, Pakistan Focuses on a Baloch Insurgency” June 16, 2020, <https://thediplomat.com/2020/06/amid-a-pandemic-pakistan-focuses-on-a-baloch-insurgency/>
 - 2 “China lays claim to Galwan Valley, blames India for border clash”, <https://www.aljazeera.com/news/2020/06/china-lays-claim-galwan-valley-blames-india-border-clash-200620072540762.html>
 - 3 “India-China tensions: Calls for boycott of Chinese products” <https://www.aljazeera.com/news/2020/06/india-china-tensions-calls-boycott-chinese-products-200620100831681.html>
 - 4 Timothy R.Heath “China’s pursuit of overseas security”, 2018 https://www.rand.org/content/dam/rand/pubs/research_reports/RR2200/RR2271/RAND_RR2271.pdf

судалгааны институтын тайланд дурдсанаар, Хятадын Шри Ланкад барьсан боомт нь худалдаа-цэргийн хосолсон зориулалттай анхны туршилтын хувилбар бөгөөд хэдийгээр иргэний зориулалттай байгууламж хэдий ч тус боомтод ХАЧА-ийн байлдааны хөлөг онгоцууд орон нутагт албан ёсоор мэдэгдэж зөвшөөрөл авах шаардлагагүйгээр зорчиж, үйл ажиллагаа явуулж байгаа юм.¹ Гэхдээ худалдаа-цэргийн давхар зориулалтаар боомтыг ашиглах нь цэргийн баазтай харьцуулахад цэргийн ажиллагаа явуулахад олон талаар хязгаарлагдмал болохыг Шри Ланкийн боомтын туршлагаар харуулж байна. Тиймээс ирээдүйд цэргийн бааз байгуулах хувилбар илүү дэмжигдэх магадлалтай.

Хятадын судлаач Шен Дингли “Хятад улс бусад улсуудыг сүрдүүлэх гэж бус харин дэлхийн энх тайван, тогтвортой байдлын төлөө гадаадад цэргийн бааз байгуулах ба гадаад дахь цэргийн баазыг чухам юу гэж нэрлэх үү гэдэг дээр санаа зовнихоос илүүтэй манай хөлөг онгоцуудыг буудаллуулж, тэнгисийн цэргүүдийг байрлуулж амрах байгууламжаар хангах талаар хүлээн авагч улс орнуудтай харилцаж тохиролцох нь чухал юм”² гэж мэдэгдсэн.

ХАЧА хилийн чанадад цэргийн баазтай болохыг үгүйсгэхгүй харин бусад улсуудыг айлгаж цочоохгүй хэрхэн эвтэйхэн зохицуулах вэ гэдэг дээр ихээхэн анхаарал хандуулж буй бололтой. Учир нь “Бүс ба зам” санаачилгад нэгдсэн хөгжиж буй ихэнх орнууд Хятадын цэргийн оролцоо нэмэгдэх вий гэж санаа зовниж буй. Тэдгээр орнууд Хятадын нөлөө, цэргийн тэлэлтээс ихээхэн эмээж, хамтын ажиллагаагаа зогсоовол “Бүс, зам” төсөл нэлээдгүй алдагдал дагуулах тул энэ асуудал дээр тун болгоомжлонгуй хандаж байгаа ажээ. Тиймээс ч сүүлийн жилүүдэд Хятадын цэргийн эрдэмтэн судлаачид гадаадын цэргийн бааз гэж нэрлэхээс илүүтэй “стратегийн түшиц цэг” (strategic strong points) зэрэг нэр томъёо судалгаандаа ашиглах болсон.

1 Мөн тэнд

2 “Don't shun the idea of setting up overseas military bases” http://www.china.org.cn/opinion/2010-01/28/content_19324522_3.htm

Ашигласан материалын жагсаалт

- M. Taylor Fravel, *Active Defense: China’s Military Strategy since 1949* (Princeton, NJ: Princeton University Press, 2019).
- Paul H.B. Godwin, “Change and Continuity in Chinese Military Doctrine, 1949–1999”, in *Chinese Warfighting: The PLA Experience since 1949*, ed. Mark A. Ryan, David M. Finkelstein, and Michael A. McDevitt (Armonk, NY: M. E. Sharpe, 2003).
- Larry M. Wortzel, “The Chinese People’s Liberation Army And Information Warfare” <https://publications.armywarcollege.edu/pubs/2263.pdf>
- 以港口为战略支点书写21世纪海上丝绸之路建设新篇章
https://www.sohu.com/a/242651424_784079
- “Pentagon repeats warning to Israel on Chinese port deal”
新时代的中国国防。白皮书 http://www.mod.gov.cn/regulatory/2019-07/24/content_4846424.htm
- 刘琳：“一带一路”沿线战略支点与军事外交建设 <http://m.dunjiaodu.com/waijiao/1562.html>
- Connor Kennedy “strategic strong points and Chinese naval strategy” <https://jamestown.org/program/strategic-strong-points-and-chinese-naval-strategy/>
- Maninder Dabas, “Here is All You Should Know About ‘String of Pearls,’ China’s Strategy to Encircle India,” *India Times*, June 23, 2017, <https://www.indiatimes.com/news/india/here-is-all-you-should-know-about-string-of-pearls-china-s-policy-to-encircle-india-324315.html>
- “All that Xi wants: China attempts to ace bases overseas” https://www.brookings.edu/wp-content/uploads/2019/09/FP_20190930_china_basing_karlin_dreyfuss.pdf
- Game of loans: How China bought Hambantota <https://www.csis.org/analysis/game-loans-how-china-bought-hambantota>
- “*China-Pakistan: A journey of friendship (1950-2020)*”
<https://www.globaltimes.cn/content/1189007.shtml>
- “China building military base in Pakistan” <https://www.washingtontimes.com/news/2018/jan/3/china-plans-pakistan-military-base-at-jiwani/>
- “Trump tweet draws China, Pakistan closer” <https://www.globaltimes.cn/content/1083361.shtml>
- 新时代的中国国防。白皮书 http://www.mod.gov.cn/regulatory/2019-07/24/content_4846424.htm

“Terror attack on Chinese consulate in Karachi foiled 3-terrorists killed”, November 23, 2018,

<https://www.dawn.com/news/1447192/terror-attack-on-chinese-consulate-in-karachi-foiled-3-terrorists-killed>

“Abducted Chinese nationals killed claims, IS” June 09, 2017,

<https://www.dawn.com/news/1338454/abducted-chinese-nationals-killed-claims-is>

“Three Chinese among 6 injured in suicide blast in Pakistan’s southwest Balochistan”

http://www.xinhuanet.com/english/2018-08/11/c_137383802.htm

“Pakistan: Gunmen target luxury hotel in China-funded port city” <https://www.dw.com/en/pakistan-gunmen-target-luxury-hotel-in-china-funded-port-city/a-48701401>

“In 3 months, BLF freedom fighters carried 26 attacks on Pakistani forces at Balochistan” <https://www.newsintervention.com/in-3-months-blf-freedom-fighters-carried-26-attacks-on-pakistani-forces-at-balochistan/>

“Amid a Pandemic, Pakistan Focuses on a Baloch Insurgency” June 16, 2020, <https://thediplomat.com/2020/06/amid-a-pandemic-pakistan-focuses-on-a-baloch-insurgency/>

“China lays claim to Galwan Valley, blames India for border clash”, <https://www.aljazeera.com/news/2020/06/china-lays-claim-galwan-valley-blames-india-border-clash-200620072540762.html>

“India-China tensions: Calls for boycott of Chinese products” <https://www.aljazeera.com/news/2020/06/india-china-tensions-calls-boycott-chinese-products-200620100831681.html>

Timothy R.Heath “China’s pursuit of overseas security”, 2018 https://www.rand.org/content/dam/rand/pubs/research_reports/RR2200/RR2271/RAND_RR2271.pdf

“Don’t shun the idea of setting up overseas military bases” http://www.china.org.cn/opinion/2010-01/28/content_19324522_3.htm